

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2025.03.12

Сайншанд


№	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжилт	Хувь				
			1	2	3	4	
Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хурээнд							
1	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг www.mrgpat.gov.mn цахим худсаар дамжуулан шинэчлэх</p>	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээг сар бүр гаргаж гаргаж сумд Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтэн, Цагдаа, Мэргэжлийн Хяналт, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг төрийн байгууллагуудыг мэдээ мэдээллээр хангаж хуулийн хэрэгжилтийг хангуйж ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2024 оны 365 тусгай зөвшөөрөл нийт нутаг дэвсгэрийн 10.3 хувийг эзлэж байгаа бөгөөд ашигт малтмалын ашиглалтын 221 тусгай зөвшөөрөл, хайгуулын 144 тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмалын 11, хайгуулын 5 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийг сар бүр гаргаж сумдын Засаг дарга нарыг мэдээллээр ханган ажиллаа. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 49 талбайд олборлолт хийгдэж, боловсруулах болон баяжуулах, бутлуурын гэх мэт 16 үйлдвэр, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт олборлолтын 1 талбай, хайгуулын 32 талбайд үйл ажиллагаа явуулж “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г eis.mn цахим мэдээллийн санд оруулснаар гүйцэтгэлийг журмын дагуу дүгнэх ажлын хэсэг ажиллаж байна. 13 сумын нутагт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай эзэмшигч 72 компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг харьяалах сумын Засаг даргаар батлуулж хог хаягдлын гэрээ, ус ашиглалтын гэрээ, тээврийн маршрут батлах зэрэг ажлуудыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн үйл ажиллагааг дэмжиж ажилласан.</p> <p>Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийг сар бүр гаргаж удирдлагууд болон сумдын Засаг дарга нарыг мэдээллээр ханган ажилласан.</p>	100%				
2	<p>Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр хандив, дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн</p>	<p>Аймгийн нутаг дэвсгэрт 2023 онд уул уурхай ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан 136 аж ахуй нэгжийн 5,4 тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөр төсөвт төвлөрч, 19 аж</p>	100%				

	дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОҮИТБСА-ЫН албанад хүргүүлэх	ахуйн нэгжээс 977,1 сая төгрөгийн хандив тусlamжийн тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын албанад хүргүүлсэн.	
Иргэдэд нээлттэй ил тод мэдээллэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хурээнд			
1	2024 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамжийн орлогын тайланг аймгийн dornogovi.gov.mn цахим хуудас болон сонин, сэтгүүл, мэдээ байршуулж нийтэд мэдээлэх	<p>Орон нутагт хэрэгжиж буй уул уурхай түүнийг дагасан төмөр зам, автозамын салбарын томоохон бүтээн байгуулалтын ажлын талаарх 6 удаагийн мэдээллийг орон нутгийн телевиз болох Dtv-ээр нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд мэдээлэл хүргэсэн.</p> <p>2023 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамжийн орлогын тайланг олон нийтэд нээлттэй ил тод мэдээллэх ажил хийгдээгүй. Аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө ХАМТДАА" 2 үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг хэвлэмэл байдлаар гарган олон нийтэд тайлагнахаар эх бэлтгэлийн ажлыг гүйцэтгэх ажил хийгдэж байгаа бөгөөд уг тайланд уул уурхайн салбараас орон нутагт төвлөрүүлсэн төлбөр, хураамж, хандив дэмжлэгийн мэдээллийг тусгасан.</p>	100%
Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хурээнд			
1	Сумдын ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх дэд зөвлөлийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын албанаас зохион байгуулсан цахим 2 удаагийн сургалтад дэд зөвлөлийн 4 гишүүн, танхимиын сургалтад 2 гишүүн тус тус хамрагдсан.</p> <p>Уул уурхай хүнд, үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан 4 танхимиын болон цахим сургалтуудад Уул уурхай, Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч нар хамрагдсан.</p>	80%
НИЙТ ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ			95%

ТАЙЛАН ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Г.МАРТ

ТАЙЛАН ГАРГАСАН:

АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ
ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Х.ОТГОНЖАРГАЛ